



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 9/55

Чингис хот

М.Шүрэнцэцэгийг Хэрлэн сумын  
Засаг дарга бөгөөд Чингис хотын  
Захирагчаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 26 дугаар зүйлийн 26.3, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны "Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ" 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж тус газрын 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 05/12535 дугаар албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5. 26.5.1, 26.5.2, 26.5.3, 26.5.4, 26.5.5 дахь заалтад заасан шаардлагыг хангасан Мягмаржавын Шүрэнцэцэгийг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагчаар томилсугай.

2. Сумын Засаг дарга М.Шүрэнцэцэгийн үндсэн цалинг 1052207 /нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон/ төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар болон бусад нэмэгдлийг тооцож цалинжуулахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010909